

ХҮЙТЭН АСФАЛЬТБЕТОН НИЙЛҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод төв болон орон нутгийн аэродромын хучилттай элементүүдийн эвдрэлийг засварлах хүйтэн асфальтбетон нийлүүлэх техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 2.1 Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн MNS1592:2023 стандартыг хангасан материалыг нийлүүлнэ.
- 2.2 Нийлүүлэх материалыг Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, техникийн шаардлагыг хангаж буйг баталгаажуулсан байна.
- 2.3 Техникийн тодорхойлолтыг хангасан талаар нотлох баримт бичиг /үйлдвэрлэгчийн бичиг баримт, гарын авлага/ ирүүлэх.

3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Техникийн үзүүлэлтүүд	Хэмжээ
1	Нягт, г/см ³	>2.0
2	Уян чанар (1/10 мм)	20-40
3	Тогтвортой байдал, 25 ⁰ С-т, Ньютон	> 2500
4	Сүвэрхэг, %	3-15
5	Усанд тэсвэртэй байдал, %	> 75
6	Ашиглах үеийн температур, ⁰ С	- 10, +35
7	Нягтруулах үеийн зузаан см	3-10
8	Өнгө	хар
9	Ширхэглэг, мм	2.5 - 8
10	Савлагаа	20-25кг, ус нэвтрүүлэхгүй савлагаатай
11	Хадгалалтын хугацаа	Тасалгааны хэмд 12 сар
12	Тоо, хэмжээ, тн	15
13	Ашиглах зориулалт	Аэродромын хучилтад засварын ажил хийх, нягтруулсны дараа материал нь бэхжиж хатууран аэродромын элементийг шууд нислэгт ашиглах боломжтой байх
14	Шинжилгээ	Үйлдвэрлэгчийн баримт бичиг, лабораторийн шинжилгээ ирүүлэх
15	Туршилт	Хүйтэн асфальтбетоны дээж ирүүлэх, дээжийг турших
16	Бусад шаардлага	Үйлдвэрлэгдсэнээс хойш 3 сарын дотор нийлүүлэх
		Ашиглалтын зааврыг Монгол хэл дээр орчуулсан байх
		Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудсыг Англи, эсхүл Монгол хувилбараар хавсаргах (MSDS-material safety data sheet)

4. ХҮЛЭЭН АВАХ

- 4.1 ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон материалыг шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр хүлээн авсанд тооцно.
- 4.2 Баталгаат хугацаа нь бараа хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 3 сар байна.
- 4.3 ИНҮТ, Аэродром, гэрэл суултын албанд нийлүүлэх.